




**ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ САЛБАРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХОЛБОГДОХ ЗААЛТЫН БИЕЛЭЛТ**

2023.12.14

Эрдэнэт

№	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ		Гүйцэтгэлийн үзүүлэлт	Хэрэгжүүлэгч байгууллага
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах	1.1.	Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага, зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг), болон лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэх	<ul style="list-style-type: none"> - Сурталчилгааны ажлыг төлөвлөн зохион байгуулсан байх - Баримтжуулж, үр дүнг тооцон тайлагнасан байх 	<p>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан соён гэгээрүүлэх аяны хүрээд Авлигатай тэмцэх газраас гаргасан албан ёсны зурагт хуудас, 4 төрлийн тараах материалыг байгууллагын</p>  <p>мэдээллийн самбарт байршуулсан. Мөн Олон нийтийн цахим сүлжээ facebook.com, erdenetgazar цахим хуудсаар "Авлигын эсрэг нэгдье", "Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа" зэрэг зурагт хуудас постер, богино хэмжээний шторкуудыг байршуулсан.</p> 
		1.2.	Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар, нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - 2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагааг г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх - Үр дүнг тооцож баримт нотолгоог хавсаргасан байх 	<p>-Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны "Шил" ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 01 дугаар албан даалгаврын хүрээнд 2008-2022 оны Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн 59, хот байгуулалтын 13 мөн "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2008 оноос хойш гаргасан дүгнэлтийг нэгтгэн ирүүлэх" гэж тусгагдсаны дагуу 2008-2023 онд</p>

				<p>ашиглалтад орсон 145 барилга байгууламжуудын мэдээллийг загвар хүснэгтийн дагуу болон улсын комиссын дүгнэлтийн хамт 2023 оны 05 дугаар сарын 24-ы өдөр аймгийн Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, ГЗБГЗЗГ-т тус тус хүргүүлсэн.</p> <p>-Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь “Нээлттэй хаалганы өдөр”-ийг 2023 оны 05 дугаар сарын 22-ноос 31-ний өдрийн хооронд Баян-Өндөр, Жаргалант сумын багуудад, 2023 оны 10 сарын 13-ны өдөр зохион байгуулж, Баян-Өндөр сумын Баян-Овоот багийн нээлттэй хаалганы өдөрлөгт оролцсон. Нээлттэй хаалганы өдөрлөгт нийт 229 иргэнд хүрч үйлчилсэн байна.</p> <p>-Мөн аймгийн Засаг дарга иргэдтэй уулзах уулзалтын үеэр газрын харилцааны цахим системийг таниулах ажлын үүднээс багийн уулзалтад очиж иргэдэд 1200 орчим тараах материал тараасан.</p> <p>-Байгууллагын цахим хуудас болон олон нийтийн цахим сүлжээгээр 2023 оны аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалт, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний мэдээлэл, түүнтэй холбоотой хууль эрх зүйн мэдээлэл, шилэн данс, хүний нөөц, төсөв санхүүгийн ил тод байдал, цахим үйлчилгээ болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой</p>
--	--	--	--	---

				137 мэдээ, мэдээллийг сурталчилж 36546 хандалтыг авсан байна.	
		1.3	<p>Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах</p>	<p>- Самбарыг ажиллуулж мэдээллийг сар бүр шинэчлэх</p> <p>- Тайланд энэ талаарх мэдээлэл, холбогдох баримтыг хавсаргасан байх</p>	<p>Байгууллагын www.erdenet.gazar.gov.mn цахим хуудсанд авлигагыг мэдээлэх 110 дугаар болон "Зөв зөвд шударга зөв" баннерыг байршуулж 9829 хандалт авсан.</p> 
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах	5.1	Албан хаагчдын авлигын эсрэг сургалт болон давтан сургалт, ёс зүйн сургалтад хамруулах	<p>- Албан хаагчдыг сургалтад бүрэн хамруулсан байх</p> <p>- Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо</p>	<p>Авлигатай тэмцэх газар, Засаг даргын Тамгын газар, Төрийн аудитын газраас хамтран 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан сургалтад ерөнхий нягтлан бодогч, Барилгын материалын үйлдвэрлэл, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Газрын татвар, төлбөр үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтнүүд хамрагдсан. Мөн 2023 оны 10 сарын 13-ны</p>

	сургалтад хамруулах				өдөр “Нийтийн албан тушаалтанд зориулсан авлигын эсрэг” сургалтад газрын дарга, 3 хяналтын улсын байцаагч нарыг хамрагдсан. Мөн Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 1 албан хаагч, төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 1 албан хаагч, Монгол Улсын урт хугацааны хөглийн бодлого “Алсын хараа-2050” сэдэвт богино хугацааны сургалтад 18 албан хаагч, Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт 6 албан хаагчийг тус тус хамруулан амжилттай төгссөн
3	Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох	3.1	Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах	- Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ОНӨҮГ, НИК, Монгол шуудантай 2023 онд гэрээгээ шинэчлэн байгуулсан. Гэрээнд авлигаас ангид байх талаар заалт оруулсан. Гэрээний эрх зүйн үндэслэлийг тухай бүр нь хянан заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.
4	Авлигын эрсдлийг бууруулах, авлига, ашиг сонирхолын зөрчил үүсгэх шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээ авч ажиллах	4.4	Шинээр томилогдсон нийтийн албан тушаалтнуудын томилогдсон шийдвэрт Хөрөнгө орлогын мэдүүлгийг мэдүүлж байх, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл бий болсон нөхцөлд хуульд заасан мэдэгдэл тайлбарыг тухай бүрт нь гаргаж байх, авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар холбогдох	- Үйлчилгээг цахимжуулах, сайжруулах арга хэмжээг авч ажилласан байх	2023 оны 01 дүгээр сарын 31-ний дотор хуулийн хугацаандаа 2022 оны хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах 4 албан хаагч хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргасан. 2023 онд шинээр албан тушаалын зэрэглэл өөрчлөгдсөн 2 албан хаагч, Мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдсантай холбоотойгоор шилжин ирсэн 3 албан хаагч, 1 түр орлон гүйцэтгэгч нийт 6 албан хаагч хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаандаа гарган Аймгийн Хууль эрх зүйн хэлтэст хянуулан Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн А/580 дугаар захирамжаар “Барилга байгууламжийг

					ашиглалтад хүлээж авах комисс"-ын гишүүдээс 2023 онд ашиглалтад оруулах 39 комисс ажилласан ба давхардсан тоогоор ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдлийг 580 хүн бөглөсөн байна. Тус мэдэгдлийг архивд хадгалж байна
5	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	5.1	Авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, тогтоосон хугацаанд тайлагнах үр дүнг албан хаагчдад болон олон нийтэд мэдээлэх	- Олон нийтэд мэдээлсэн байх /цахим болон самбараар/	-Байгууллагын www.erdenet.gazar.gov.mn цахим хуудасны ил тод байдлын цэсэнд 2021, 2022, 2023 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, тайлан мэдээг оруулж байна.
		5.5	Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх ажлыг эрчимжүүлж, цахимаар үзүүлэх үйлчилгээний тоо, чанарыг нэмэгдүүлэх	- Цахим үйлчилгээний тоо	-Газрын кадастрын мэдээллийн санд нийт 2800 цахим хүсэлт ирүүлснээс 2165 хүсэлтийг Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэн холбогдох журмын дагуу шийдвэрлэх үйл ажиллагааг авч ажилласан бөгөөд харин газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй мөн шаардлага хангаагүй 635 хүсэлтийг буцаасан. -Газрын биржийн www.mle.mn цахим программ хангамжид бүртгэгдсэн газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг Газрын үнэлгээний системд оруулах ажлыг хийлээ. 2023 онд 813 нэгж талбарын үнийг хөрвүүлж, эдийн засгийн үнэлгээ хийхэд ашиглаж байна. Орхон аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөл бүхий 21 аж ахуйн нэгжээс цахим системээр дамжуулан нийт 719 нэгж талбар бүхий 103.4686 га газарт газрын төлөв байдал чанарын захиалгат хянан баталгааны тайлан, дүгнэлт ирүүлснийг хуулийн хугацаанд нь баталгаажуулан ажиллаа. Цахим системээр

			<p>хянан баталгааны тайлан, дүгнэлтийг баталгаажуулахад гарч буй алдаа, зөрчлийг засварлаж, тайлангийн үр дүнг сайжруулах зөвлөгөө зөвлөмжийг эрх бүхий мэргэжлийн байгууллагуудад тухай бүрд нь өгч ажилласан.</p> <p>-Аймгийн хэмжээнд 2024 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршлын судалгаа, хэмжилтүүдийг хийж, Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд төсөл үүсгэн иргэдийн саналыг авч Баян-Өндөр суманд 399 иргэнд 26.64 га, Жаргалант суманд 50 иргэнд 5.78 га буюу аймгийн хэмжээнд 449 иргэнд 32.42 га газрыг өмчлүүлэхээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 13/04 тоот тогтоолоор батлуулж Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн газарт 2023 оны 696 тоотоор хүргүүлсэн.</p> <p>-Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоолыг үндэслэн Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 2023 онд Хот байгуулалтын кадастрын цахим систем /www.urban.gov.mn/-ээр ирсэн 89 иргэн, ААН байгууллагын хүсэлт ирсэн бөгөөд аймгийн хэмжээнд 159 байршлын схем боловсруулж, архитектур төлөвлөлтийн даалгавар-81, эх загвар зураг- 46, ажлын зураг-58, барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл- цахимаар 13, уламжлалт бичмэл хэлбэрээр 6 барилга байгууламжийн ажилд эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон байна. Ажил эхлүүлэх,</p>
--	--	--	--

					<p>үргэлжлүүлэх зөвшөөрөл, мэдээллийг БХБСайдын 2020 оны 3-р сарын 11-ний 55-р тушаалын 2-р хавсралт маягтын дагуу 1,2,3,4-р улирлын байдлаар гаргаж Барилга, хөгжлийн төвд цаасаар болон цахим хаягаар тус тус хүргүүлсэн.</p> <p>2023 онд нийт 1750 өргөдөл, гомдол ирснээс Нийт шийдвэрлэн хариу өгсөн 1628 өргөдөл гомдол байгаа бол хугацаандаа яваа 122 өргөдөл гомдол байна. I, II, III, IV улирлын иргэдээс хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээг хугацаанд нь гарган АЗДТГ-т хүргүүлсэн.</p> <p>Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төвийн 11-11 утсанд 7 гомдол ирснийг ажлын 5 хонгийн дотор шийдвэрлэн иргэн бүрд тайлбар, авсан арга хэмжээний талаар мэдээллийг утсаар хүргүүлсэн.</p> <p>АЗДТГ-ын дэргэдэх иргэдийн санал, гомдол хүлээн авах 70353511 утсанд ирсэн нийт 124 гомдол хүсэлт байсныг ажлын 3 хоногийн дотор тухай иргэнтэй холбогдон шаардлагатай тайлбар, зөвлөмж хариуг өгөн ажилласан.</p>
6	Байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй	6.2	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах	- Хуульд заасан нээлттэй мэдээллүүдийг бүрэн байршуулсан,	Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах хуулийн дагуу байгууллагын www.erdenet.gazar.gov.mn цахим хуудсанд мэдээллүүдийг байршуулан ажиллаж байна.

	байдлыг сайжруулах			мэдээллийг шинэчилсэн байх	
		6.3.3	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийн хэрэгжилтийн байдалд хяналт шалгалтыг зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээг авах	- Мэдээллийг бүрэн байршуулсан байх	Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх нийт байгууллагын мэдээллийг хуулийн хугацаанд оруулан, тайлагнаж байна. Шилэн дансны сайтад үйл ажиллагаа, худалдан авалт, хүний нөөц, төсөв санхүүгийн нийт 20 үзүүлэлтийг сар, улирал, хагас бүтэн жилээр байршуулдаг бөгөөд үүнээс төсөв санхүүгийн 9 үзүүлэлтийг сар бүр шинэчлэн, зохих хугацаанд нь байршуулан ажилласан.
7	Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх	7.1	Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, оролцогчдод мэдээллийг хүртээмжтэй түгээх, тендерт оролцох, тендерийн үйл явцын талаар мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх	- Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр явуулах - Оролцогчдод мэдээлэл өгөх зохион байгуулсан байх	Байгууллагын хэмжээнд худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр явуулах төсөв 2023 онд батлагдаагүй тул худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр явуулаагүй байна.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
ХЯНАСАН: ГАЗРЫН ДАРГА

О.ДҮҮРЭНЖАРГАЛ
Д.ЦОЛМОН